

Оюутны өөрийн үр дүнт шинж болон нийгмийн дасан зохицохуйн хамаарлыг судалсан нь

Өлзийбаяр Намираа

Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Өвөр Монголын Өөртөө Засах Орон, Хөлөнбуйр хот, Хөлөнбуйр Их Сургууль, Боловсрол Судлалын Тэнхим

Холбоо барих зохиогч: cnme0701@gmail.com

ORCID: <https://orcid.org/0009-0003-3142-2505>

Хүлээн авсан: 2023.05.13

Засварласан: 2023.09.19

Хэвлэлтэд авсан: 2023.10.20

Хураангуй

Энэхүү судалгаа нь оюутны өөрийн үр дүнт шинж болон нийгмийн дасан зохицохуйн хамаарлыг судалсан. Бидний судалгаа нь XXI зууны чухал чадварт тооцогдож буй зөөлөн ур чадварын нэг болох нийгмийн дасан зохицохуй болон өөрийн үр дүнт шинжийн хамаарлыг судалсан нь шинэлэг талтай. Тус судалгаанд ӨМӨЗО-ы таван их сургуулийн 2713 оюутан оролцсон. Судалгааны үр дүнд оюутны нийгмийн дасан зохицохуй нь долоон үзүүлэлтийн (суралцахуйн, хүмүүстэй, "Би"-ийн, мэргэжил сонголтын, амьдралд бие даах, хүрээлэн буй орчинд, соматик сэтгэцийн шинж) хувьд дундаж нь ($M=3,68$) дунджаас дээгүүр буюу сайн, өөрийн үр дүнт шинж нь нийт оюутнуудын хувьд ($M=2.58$) дунджаас дээгүүр байна. Мөн өөрийн үр дүнт шинжийн Т тестийн шинжилгээний үр дүнд хүйсийн хувьд ялгаатай ($p = 0.001$) буюу эрэгтэй оюутнуудын өөрийн үр дүнт шинж өндөр, нийгмийн дасан зохицохуйн хувьд Эрэгтэй, эмэгтэй оюутнуудын нийгмийн дасан зохицохуйн нийт оноо ($p=.049$) болон хүрээлэн буй орчноо цогцоор нь хүлээн зөвшөөрөх чадвар ($p = .001$) нь хүйсээс хамааран ялгаатай, хот, хөдөөгөөс шалтгаалаан нийгмийн дасан зохицохуйн нийт оноо ($p = .008$) болон суралцахуйн дасан зохицох чадвар ($p=.000$), хүмүүстэй дасан зохицох чадвар ($p = .010$), "Би"-ийн дасан зохицох чадвар ($p=.000$), мэргэжил сонголтдоо дасан зохицох чадвар ($p=.009$) зэрэг нь тодорхой хэмжээнд тус тус ялгаатай байна. Мөн нийгмийн дасан зохицохуй болон өөрийн үр дүнт шинж нь ($r = .329$) дунд зэрэг эерэг хамааралтай, өөрийн үр дүнт шинж нь нийгмийн дасан зохицохуйд 10.8% ($\Delta R^2 = 0.108$) -р нөлөөлж байна.

Түлхүүр үг: оюутан, өөрийн үр дүнт шинж, нийгмийн дасан зохицохуй



Удиртгал

21-р зууны их сургуулийн оюутнууд олон талаар сурч хөгжих өргөн боломжтой байгаа хэдий ч нийгмийн орчин хурдацтай өөрчлөгдөж, өрсөлдөөн нэмэгдэж байгаагай холбоотойгоор тэдний өмнө төрөл бүрийн бэрхшээл тулгарч байна. Иймээс их дээд сургуулийн оюутан залуучуудыг амьдралд бэлтгэх, төгсөөд ажил хөдөлмөр эрхлэх боломж бололцоог сайжруулах асуудал чухлаар тавигдаж байна. Тухайлбал оюутнууд сургуулиа төгсөхөд практик туршлага, нийгмийн ур чадвар дутмагаас ажилд орох, ажлын байранд дасан зохицоход бэрхшээлтэй тулгардаг бол зарим оюутнууд шалгалтын дүн, хичээлийн мэдлэгийг хэт хөөцөлдөж зөөлөн чадвараа хөгжүүлэхэд төдийлөн анхаарахгүй байна (Klaus, 2003, p. 5). Стэнфордын судалгааны хүрээлэн (Stanford Research Institute) болон Карнеги Меллоны сангийн (Carnegie Mellon Foundation) хийсэн судалгаанд урт хугацааны ажлын амжилтын 75% нь хүмүүстэй харилцах, зөөлөн ур чадвараас хамаардаг бол ердөө 25% нь техникийн ур чадвараас хамаардаг талаар дурдсан байдаг (Deera, 2013, p. 3). Манчестерийн их сургуулиас ийм судалгаа явуулсан бөгөөд компаниуд ажилчдын багаар ажиллах чадвар, харилцааны ур чадвар, үнэнч шударга байдал, хариуцлага болон бусад зөөлөн ур чадварт илүү анхаарал хандуулдаг байна (David, 2003, pp. 10-11).

Канадын нэрт сэтгэл зүйч Альберт Бандура өөрийн үр дүнт шинж нь “Тодорхой үр дүнд хүрэхэд зайлшгүй шаардагдах зан үйлийг гүйцэтгэх авьяас чадвар байгаа гэдэгтэй итгэх хувь хүний итгэл үнэмшлийг илэрхийлдэг” (Bandura, 1997, p.45) гэж тайлбарласан байдаг. Оюутнуудын өөрийн үр дүнт шинжийн түвшин нь тэдний зан үйлийн сонголт, мөн зан үйлийн хичээл зүтгэл, тууштай байдал зэрэгт нөлөөлдөг байна. Монголын судлаач Ш.Батболд өөрийн үр дүн өндөртэй хүмүүс бол хөдөлмөрч, амжилттай байж, тууштай байж чаддаг (Батболд, 2022, х.130) хэмээн тодорхойлсон байна.

Нийгмийн дасан зохицох гэдэг нь хувь хүн байнга өөрчлөгдөж буй нийгмийн орчинд, суралцах арга барил, хүмүүсийн хоорондын харилцаа, ирээдүйн хөгжил, сэтгэл зүйн байдал гэх мэт зүйлсэд хариу үйлдэл үзүүлж, нийгмийн шинэ орчинд хувь хүний дасан зохицох арга барилыг байнга өөрчилж, ирээдүйнхээ төлөө амжилттай суралцаж түүнийгээ биелүүлэх явдал гэж тайлбарласан байна. Өмнө хийгдсэн судалгаанууд нь их дээд сургуулийн оюутнуудын сурлагын амжилтад гол анхаарлаа хандуулдаг байсан бол сүүлийн үед оюутнуудын нийгэмд дасан зохицох судалгаанд анхаарлаа төвлөрүүлэх болсон (Fuqun, 2018, p. 3).

Энэхүү нийгмийн дасан зохицохуйн талаар Монголын судлаач Ш.Батболд (2012, х.2-50), Ж.Даваа (2017, х. 135-139), Д.Нямгэрэл (2017, х. 1-70) нар судалсан байна.

"Зөөлөн ур чадвар" нь амьдрах ухаан, сэтгэл хөдлөлийн оюун ухаан, нийгмийн ур чадвар, хүнтэй харилцах чадвар, дасан зохицохуй зэрэг ойролцоо утга бүхий нэр томъёотой нягт уялдаж өгдөг бөгөөд эдгээрийн аль аль нь дээрх өргөн хүрээтэй тодорхойлолтод багтаж байна. Өөрийн үр дүнт шинж, нийгмийн дасан зохицохуйг хамтад нь судлах нь судалгааны ач холбогдол, эрэлт хэрэгцээг тодорхойлох нэг үндэслэл болж байгаа юм.

Судалгааны арга зүй

Судалгаанд ӨМӨЗО-ы 5 их сургуулиас (Хөлөнбуйр дээд сургууль, Багшийн Их Сургууль, Тариалангийн Их Сургууль, Технологийн Их Сургууль, Үндэсний Их Сургуулиас) нийт 2713 оюутан оролцсон бөгөөд эрэгтэй 979, эмэгтэй 1743 оюутан хамрагдсан.

Судалгааны арга зүй нь :

1. Хятадын эрдэмтэн LuXieFeng-ий 2003 онд зохицуулан хэрэглэсэн нийт 66 асуулт, Лайкерт шкал бүхий 7 хэмжүүртэй “Дасан зохицох чадварыг үнэлэх асуулга” (CSAI). Судалгааны үр дүнд 3.55-с дээш бол сайн, доош бол муу гэж дундаж хэм хэмжээг тодорхойлсон (Xiefeng, 2003, pp. 12-14).
2. Шварцер болон түүний хамтрагчдын (Jerusalem, M; Schwarzer, Ralf, 2012, p. 4) 1981 онд боловсруулсан 10 асуулт бүхий “Өөрийн үр дүнт шинжийн ерөнхий хэмжүүр”-ийг (GSES) Хятадын эрдэмтэд болох Ван Цай Кан, Ху Жон Пен, Лүи Ёнг нар 2001 онд зохицуулан хэрэглэсэн арга зүйгээр судалгааг авсан. Тус судлаачид судалгааны үр дүндээ Хятад улс дахь өөрийн үр дүнт шинжийн хүйсийн дундаж оноо нь **эрэгтэй дундаж хэм хэмжээ (2.69-с)** харин **эмэгтэй дундаж хэмжээ (2.55-с)** дээш бол өөрийн үр дүнт шинж сайн, харин тус онооноос доогуур бол өөрийн үр дүнт шинж муу хэмээн Хятад улс дахь эрэгтэй, эмэгтэй хүний өөрийн үр дүнт шинжийн дундаж хэм хэмжээг тодорхойлсон байдаг (Kang, Wang Cai; Hu, Zhong Feng; Liu, Yong ;, 2001, pp. 37-40)

Судалгааны мэдээллийг SPSS 26.0 программ ашиглан статистик боловсруулалт хийсэн. Ерөнхий үзүүлэлтүүдийн үр дүнг тооцоходоо дундаж, медиан, стандарт хазайлт зэрэг тодорхойлох статистик шинжилгээ хийсэн. Хамаарах болон үл хамаарах хувьсагчдын хоорондын хамаарлыг тодорхойлохдоо Пирсоны корреляцийн коэффициент, шугаман регрессийн шинжилгээ зэргийг ашигласан.

Хүснэгт 1

Судалгаанд ашигласан арга зүй тус бүрийн баталгаат чанар болон тохироц чанар

№	Арга зүй	Баталгаат чанар (Кронбах альфа)	Тохироц чанар (КМО)
1	Оюутны нийгмийн дасан зохицохуйг үнэлэх асуулга (CSAI)	a=.934	.975
2	Өөрийн үр дүнт шинжийн ерөнхий шкал(GSES)	a=.921	.942

Бид судалгааны ажлын хүрээнд нийт түүвэр болох 2713 судлуулагчдын түүвэр дээр дахин баталгаат чанар болон тохироц чанарыг тооцон үзсэн.

Хүснэгт 1-ээс үзэхэд түүврийн хүрээнд судалгаанд ашигласан 2 арга зүйн Кронбах альфа коэффициент (a=.921, .934, .947) гарсан нь баталгаат чанарын үзүүлэлтийг (a > 0.7) хангаж байна. Дээрх судалгааны арга зүй тус бүрийн

баталгаат чанар болон тохироц чанар тестийн стандарт шаардлагыг хангасан тул цаашид судалгааны үр дүнд боловсруулалт хийсэн.

Судалгааны үр дүн

Энэхүү судалгаагаар 2713 суралцагчдын судалгааны үр дүнд боловсруулалт хийхэд оюутнуудын өөрсдийн үр дүнт шинжийн дундаж нь ($M=2.58$, стандарт хазайлт = 0.619) дундаас дээгүүр буюу сайн байна.

Оюутны өөрийн үр дүнт шинжийн хүйсийн ялгаа

Судалгааны үр дүнгээс харахад их сургуулийн оюутнуудын өөрийн үр дүнт шинж нь хүйсээс хамааран ялгаатай байна. Цаашлаад эрэгтэй оюутнуудын өөрийн үр дүнт шинж нь эмэгтэй оюутнуудаас мэдэгдэхүйц өндөр байна (эрэгтэй дундаж = 2.71, эмэгтэй дундаж 2.50, t утга = 8.31, $p = 0.001$).

Үүнээс үзвэл эрэгтэй хүмүүсийн өөрийн үр дүнт шинж эмэгтэй хүмүүсийн өөрийн үр дүнт шинжээс өндөр байдгийг харж болно.

Оюутны өөрийн үр дүнт шинжийн хот, хөдөөгийн ялгаа

Харин оюутнуудын өөрийн үр дүнт шинжийн дундаж хэм хэмжээ нь тэдний хот эсвэл хөдөө төрсөн эсэхээс үл хамаарч байна (эрэгтэй дундаж = 2.58, эмэгтэй дундаж 2.58, t утга = 0.21, $p = 0.83$).

Нийгмийн дасан зохицохуйн судалгааны үр дүн

Энэхүү судалгаагаар оюутнуудын нийгмийн дасан зохицохуйн нийт үзүүлэлт ба дараах долоон хэмжээсийг тодорхойлсон судалгааны үр дүнт гаргасан.

Хүснэгт 2

Оюутнуудын нийгмийн дасан зохицохуйн үзүүлэлтүүд

	N	M	SD
C1	2713	3.66	.850
C2	2713	3.77	.691
C3	2713	3.65	.653
C4	2713	3.38	.695
C5	2713	4.00	.698
C6	2713	3.50	.782
C7	2713	3.81	.787
Нийт оноо	2713	3.68	.592

Суралцахуйн дасан зохицох чадвар (C1), Хүмүүстэй дасан зохицох чадвар (C2), “Би”-ийн дасан зохицох чадвар (C3), Мэргэжил сонголтдоо дасан зохицох чадвар (C4), Амьдралд бие даахад дасан зохицох чадвар (C5), Хүрээлэн буй орчноо цогцоор нь хүлээн зөвшөөрөх (C6), Соматик сэтгэцийн эмгэгийн шинж тэмдэг (C7), Нийгмийн дасан зохицохуйн нийт оноо (C), $N = 2713$, $M = 3.68$, $SD=0.59$

Хүснэгт 2-оос харахад оюутнуудын нийгмийн дасан зохицохуйн нийт оноо болон 7 хэмжүүр тус бүрийн үзүүлэлт нь дундаас дээш түвшинд байна. Энэ нь оюутнуудын нийгмийн дасан зохицохуйн байдал сайн байгааг харуулж байна. Бүх хэмжээсүүдээс үзэхэд судалгаанд оролцогч оюутнуудын “Би”-ийн дасан зохицох чадвар нь хамгийн өндөр оноотой ($M=4.00$) ба мэргэжил сонголтдоо дасан зохицох чадвар нь хамгийн бага оноотой ($M=3.38$) байна.

Оюутны нийгмийн дасан зохицохуйн хүйсийн ялгаа

Их сургуулийн эрэгтэй эмэгтэй оюутнуудын нийгмийн дасан зохицохуйн ялгааг шалгах зорилгоор бие даасан түүвэр t-тестийг хийсэн.

Хүснэгт 3

Оюутны нийгмийн дасан зохицохуйн хүйсийн ялгаа

	Хүйс	N	M	SD	t	p
C1	Эрэгтэй	979	3.63	.889	-1.383	.167
	Эмэгтэй	1734	3.68	.831		
C2	Эрэгтэй	979	3.74	.706	-1.772	.076
	Эмэгтэй	1734	3.79	.682		
C3	Эрэгтэй	979	3.63	.682	-1.116	.264
	Эмэгтэй	1734	3.66	.636		
C4	Эрэгтэй	979	3.37	.682	-.612	.541
	Эмэгтэй	1734	3.39	.703		
C5	Эрэгтэй	979	3.99	.757	-.624	.533
	Эмэгтэй	1734	4.00	.669		
C6	Эрэгтэй	979	3.44	.783	-3.454***	.001
	Эмэгтэй	1734	3.54	.779		
C7	Эрэгтэй	979	3.77	.829	-1.876	.061
	Эмэгтэй	1734	3.83	.762		
Нийт оноо	Эрэгтэй	979	3.65	.616	-1969*	.049

Хүснэгт 3-ыг дүгнэвэл их сургуулийн эрэгтэй, эмэгтэй оюутнуудын нийгмийн дасан зохицохуйн нийт оноо ($p=.049$) болон хүрээлэн буй орчноо цогцоор нь хүлээн зөвшөөрөх чадвар ($p=.001$) нь хүйсээс хамааран ялгаатай байна.

Эмэгтэй оюутнуудын дундаж оноо ($M=3.69$) эрэгтэй оюутнуудын дундаж онооноос ($M=3.65$) өндөр байгаа боловч бусад хэмжээст мэдэгдэхүйц ялгаа байхгүй байна. Энэ нь оюутнуудын нийгмийн дасан зохицох ерөнхий хэмжээс нь эрэгтэй, эмэгтэй оюутнуудын хүйсийн хувьд харьцангуй тэнцвэртэй байгааг харуулж байна.

Оюутнуудын хүрээлэн буй орчноо цогцоор нь хүлээн зөвшөөрөх чадварын хувьд эмэгтэй оюутнууд ($M=3.44$) эрэгтэй оюутнуудаас өндөр оноо ($M=3.54$) авсан бөгөөд шалтгаан нь эрэгтэй, хүмүүсийн зан чанарын ялгаатай холбоотой байж болох юм.

Оюутны нийгмийн дасан зохицохуйн хот, хөдөөгийн ялгаа

Их сургуулийн оюутнуудын нийгмийн дасан зохицохуйн хот, хөдөөгийн ялгааг шалгахын тулд бие даасан түүвэр Т-тест хийсэн бөгөөд тодорхой үр дүнг хүснэгт үзүүлэв.

Хүснэгт 4

Оюутны нийгмийн дасан зохицохуйн хот, хөдөөгийн ялгааны харьцуулалт

	Төрсөн газар	N	M	SD	t	p
C1	Хот	1020	3.74	.852	3.568***	.000
	Хөдөө	1693	3.62	.850		
C2	Хот	1020	3.82	.690	2.588**	.010
	Хөдөө	1693	3.75	.691		
C3	Хот	1020	3.72	.660	4.230***	.000
	Хөдөө	1693	3.61	.645		
C4	Хот	1020	3.43	.712	2.621**	.009
	Хөдөө	1693	3.35	.683		
C5	Хот	1020	4.02	.708	1.273	.203
	Хөдөө	1693	3.98	.691		
C6	Хот	1020	3.49	.808	-.614	.539
	Хөдөө	1693	3.51	.766		
C7	Хот	1020	3.84	.794	1.499	.134
	Хөдөө	1693	3.79	.782		
Нийт оноо	Хот	1020	3.72	.597	2.650**	.008
	Хөдөө	1693	3.65	.589		

Хүснэгт 4-ийг дүгнэхэд хот, хөдөөгөөс шалтгаалаан нийгмийн дасан зохицохуйн нийт оноо ($p=.008$) болон суралцахуйн дасан зохицох чадвар ($p=.000$), хүмүүстэй дасан зохицох чадвар ($p=.010$), “Би”-ийн дасан зохицох чадвар ($p=.000$), мэргэжил сонголтдоо дасан зохицох чадвар ($p=.009$) зэрэг нь тодорхой хэмжээнд ялгаатай байна.

Хотын их сургуулийн оюутнууд нь хөдөөгийн оюутнуудаас хэмжээс онооны хувьд өндөр байна. Харин амьдралд бие даахад дасан зохицох чадвар, хүрээлэн буй орчноо цогцоор нь хүлээн зөвшөөрөх чадвар, соматик сэтгэцийн эмгэгийн шинж тэмдэг зэрэг чадвар нь хот, хөдөөгөөс шалтгаалан мэдэгдэхүйц ялгаагүй байна.

Хятадын судлаач Шиүлин Их сургуулийн нэгдүгээр курсийн оюутнуудаас “Би”-н дасан зохицох, сэтгэцийн эрүүл мэндийн талаар хийсэн судалгаагаар хот, хөдөөгийн оюутнууд Би-д дасан зохицох үр дүнд ихээхэн ялгаатай байгааг олж тогтоосон бөгөөд хотын оюутнууд хөдөөгийн оюутнуудаас илүү “Би”-д дасан зохицох чадвартай болохыг тогтоожээ. Амьдралд дасан зохицох чадварын хувьд бол хөдөө орон нутгийн оюутнууд хотын оюутнуудаас дээгүүр байдаг (Xiuling, 2008, pp. 1-6).

Нийгмийн дасан зохицохуй болон өөрийн үр дүнт шинж хоорондын хамаарал

Хүснэгт 5

Нийгмийн дасан зохицохуй болон өөрийн үр дүнт шинжийн хамаарал

	C1	C2	C3	C4	C5	C6	C7	C	S
C1	1								
C2	.659**	1							
C3	.564**	.738**	1						
C4	.558**	.621**	.634**	1					
C5	.551**	.599**	.549**	.429**	1				
C6	.583**	.627**	.528**	.527**	.470**	1			
C7	.753**	.673**	.556**	.474**	.601**	.570**	1		
C	.848**	.869**	.800**	.753**	.743**	.772**	.832**	1	
S	.220**	.329**	.332**	.374**	.191**	.251**	.182**	.329**	1

Суралцахуйн дасан зохицох чадвар (C1), Хүмүүстэй дасан зохицох чадвар (C2), “Би”-ийн дасан зохицох чадвар (C3), Мэргэжил сонголтдоо дасан зохицох чадвар (C4), Амьдралд бие даахад дасан зохицох чадвар (C5), Хүрээлэн буй орчноо цогцоор нь хүлээн зөвшөөрөх (C6), Соматик сэтгэцийн эмгэгийн шинж тэмдэг (C7), Нийгмийн дасан зохицохуйн нийт оноо (C), Өөрийн үр дүнт шинж (S).

Хүснэгт 5-аас үзэхэд өөрийн үр дүнт шинж нь оюутнуудын нийгмийн дасан зохицох чадвартай дунд зэрэг эерэг хамааралтай ($r=0.329^{**}$) байна. Энэ нь өөрийн үр дүнт шинж өндөртэй оюутнууд нийгмийн дасан зохицох чадвар сайжирна.

Өөрийн үр дүнт шинж болон нийгмийн дасан зохицохуйн регрессийн шинжилгээ

Үл хамаарах хувьсагчаар өөрийн үр дүнт шинж, нийгмийн дасан зохицох чадварыг хамаарах хувьсагч болгон ашиглаж регрессийн шинжилгээ хийсэн. Регрессийн шинжилгээний үр дүнг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 6

Өөрийн үр дүнт шинж болон нийгмийн дасан зохицохуйн шугаман регрессийн шинжилгээ

Үл хамаарах	Хамаарах	β	t	R ²	ΔR^2	F
Өөрийн үр дүнт шинж	Нийгмийн дасан зохицохуй	0.329	18.149	0.108	0.108	329**

Хүснэгт 6-г дүгнэхэд нийгмийн дасан зохицолд өөрийн үр дүнт шинжийн регрессийн тэгшитгэл нь ач холбогдолтой ($F=329$, $P=.000$), $\Delta R^2=0.108$) айгаа бөгөөд нийт онооны өөрчлөлтийн 10.8% байгааг харуулж байна. Энэ нь өөрийн үр дүнт шинж нь нийгмийн дасан зохицохуйд 10.8%-р нөлөөлж байна.

Хэлэлцүүлэг

Ран, Поулова зэрэг судлаачид (2022) оюутнуудын сэтгэл хөдлөлийн оюун ухаан болон тэдний ажил мэргэжлээр шийдвэр гаргах өөрийн үр дүнт шинжийн хооронд мэдэгдэхүйц эерэг хамаарал байгааг судалгаагаар тогтоосон байдаг (Z, Ran; Nisar, F; Zeb, S; Poulouva, P., 2022, pp. 68-72).

Лүй Айчин болон түүний хамтрагчид (2008, х.1) хамаарлын шинжилгээ болон регрессийн шинжилгээгээр сэтгэл хөдлөлийн оюун ухаан, өөрийн үр дүнт шинж нь зөвхөн ажил мэргэжлийн төлөвшилд шууд нөлөөлөөд зогсохгүй сэтгэл хөдлөлийн оюун ухаан нь өөрийн үр дүнт шинжээр дамжуулан ажил мэргэжлийн төлөвшилд шууд бусаар нөлөөлдөг болохыг олж тогтоосон бөгөөд өөрийн үр дүнт шинж нь сэтгэл хөдлөлийн оюун ухаан, ажил мэргэжлийн төлөвшил хооронд завсрын хувьсагчийн үүргийг гүйцэтгэдэг байна (Aiqin, 2008, p. 44). Мөн бидний судалгааны үр дүнд өөрийн үр дүнт шинж болон нийгмийн дасан зохицохуй нь хамааралтай төдийгүй өөрийн үр дүнт шинж нь нийгмийн дасан зохицохуйд нөлөөлдөг гэсэн судалгааны үр дүн гарсан.

Энэхүү судалгаануудаас үзэхэд зөөлөн ур чадваруудын хэсэг болох нийгмийн дасан зохицохуй, сэтгэл хөдлөлийн оюун зэрэгт өөрийн үр дүнт шинж нь мэдэгдэхүйц хамааралтай, нөлөөлөхүйц байгаагаас гадна сэтгэл судлал, спорт, суралцахуйн асуудлуудад нөлөөлж байгаа нь сэтгэл судлаачдын судлах чухал хэрэгцээт асуудал болж байна.

Дүгнэлт

XXI зуунд чухал тооцогдож буй зөөлөн ур чадварт нөлөөлж буй нийгмийн дасан зохицохуй болон өөрийн үр дүнт шинжийн хоорондоо хамааралтай гэсэн бидний урьдчилсан санаа энэхүү судалгаагаар батлагдсан. Өөрөөр хэлбэл нийгмийн дасан зохицохуй болон өөрийн үр дүнт шинж нь хоорондоо хамааралтай ба өөрийн үр дүнт шинж өндөртэй байх нь нийгмийн дасан зохицохуйд нөлөөлдөг байна.

Судалгааны нийт үр дүнгээс харахад оюутнуудын өөрийн үр дүнт шинж болон нийгмийн дасан зохицохуйн үзүүлэлтүүд дунджаас дээш түвшинд байгаа бөгөөд хоорондоо шууд хамааралтай байна. Мөн нийгмийн дасан зохицохуйд өөрийн үр дүнт шинж нөлөөлөхүйц байна.

Төгсгөлд нь өөрийн үр дүнт шинж өндөр хүний нийгмийн дасан зохицол сайн байх боломжтой байгаа бөгөөд зөөлөн ур чадварын нэг нийгмийн дасан зохицохуйг сайжруулахын тулд өөрийн үр дүнт шинжийг сайжруулах ёстой байна.

Хязгаарлагдмал тал

Тус судалгаанд зөвхөн ӨМӨЗО-ы 5 их сургуулийн 2713 оюутан оролцсон. Энэхүү судалгааг Монгол улсад сурч байгаа их сургуулийн оюутнуудын судалгааны үр дүнтэй харьцуулж үзээгүй болно. Энэхүү судалгааг цаашид Монгол их сургуулийн оюутнуудаас авч харьцуулан судлах төлөвлөгөөтэй байна.

Талархал

Энэхүү судалгааг ӨМӨЗО-ын 5 их сургуулиас (Хөлөнбуйр их сургууль, Тариалангийн их сургууль, Багшийн их сургууль, Технологийн их сургууль, Үндэсний их сургууль) 2713 оюутнаас судалгаа авсан. Энэхүү судалгаанд оролцсон нийт оюутнууд болон тусалсан багш нарт талархал илэрхийлье.

Ашигласан бүтээлийн жагсаалт

- Klaus, P. (2003). *The hard truth about soft skills*. Boston: Celledwell publishing.
- Xiefeng, L. (2003). *Compilation and Standardization of College Students' Adaptability Scale*.
- Xiuling, S. (2008). *Research on Role Adaptation and Mental Health of College Freshmen*.
- Aiqin, L. (2008). College students career maturity and emotional intelligence: the mediating role of self-efficacy. *Journal of peking university (Natural science edition)*, 44.
- Bandura, A. (1997). *Self-Efficacy: The exercise of control*. New York: Freeman.
- David, T. (2003). *The Spirituality Revolution: The Emergence of Contemporary*. Sydney: harber Collins Publisher.
- Deepa, S. (2013). Do Soft Skills Matter?-Implications for Educators Based on Recruiters' Perspective. *The IUP Journal of Soft Skills*, 11-13. doi: <https://ssrn.com/abstract=2256273>
- Fuqun, X. (2018). Social mobility, urban-rural background and urban social adaptation of working college graduates—Based on a questionnaire survey of cities across the country. *Jinyang Academic Journal*, 3. doi:10.16392/j.cnki.14-1057/c.2018.03.010
- Jerusalem, M; Schwarzer, Ralf. (2012). The general Self-Efficacy scale (GSE). *ResearchGate*, 4. doi:12:329-345
- Kang, Wang Cai; Hu, Zhong Feng; Liu, Yong ;. (2001). Evidences for reliability and validity of the Chinese version of general Self-Efficacy scale. *Chinese Journal of Applied Psychology*, 37-40. doi:1006-6020(2001)-01-0037-04
- SiXiuling. (2008). Characteristics and Influencing Factors of Adolescents' Social Adaptation Behavior. *Journal of Capital Normal University Social Science Edition*.
- Z, Ran; Nisar, F; Zeb, S; Poulouva, P;. (2022). The impact of emotional intelligence on career decision making difficulties and generalized Self-Efficacy among university students in China. *Psychological research*, 68-72. doi:<https://doi.org/10.2147/PRBM.S358742>
- Батболд , Ш. (2022). *Амьдралын психологи II*. Улаанбаатар: ТЭПЭ.

- Батболд, Ш. (2012). *Оюутны дасан зохицоог судалсан нь*. Улаанбаатар: МУИС.
- Даваа, Ж. (2017). *Боловсрол судлал. Боловсрол судлал, 135-139*. Улаанбаатар: МУИС ХЭВЛЭЛ.
- Нямгэрэл, Д. (2017). *Оюутны сэтгэл зүйн дасан зохицолыг судалсан нь*. Улаанбаатар: МУИС.

Studying the relationship between students' self-efficacy and social adaptation

Namier Ulziibayar

Department of Education, Hulonbuir University, Hulonbuir City, Inner Mongolia Autonomous Region (IMAR), China

Corresponding author: cnme0701@gmail.com

ORCID: <https://orcid.org/0009-0003-3142-2505>

Received: 2023.05.13

Revised: 2023.09.19

Accepted: 2023.10.20

Abstract

This study examined the relationship between student self-efficacy and social adaptability. Our research is innovative in that it examines the relationship between social adaptability and self-efficacy, which is one of the soft skills considered to be important skills of the 21st century. 2,713 students from five universities of Inner Mongolians participated in the study. According to the results of the research, the student's social adaptation in 7 parameters (learning, "I" with people, professional choice, self-reliance in life, environment, somatic mental characteristics) is above average or good ($M=3.68$), self-efficacy is above average for all students ($M=2.58$). Also, according to the results of the T-test analysis of self-efficacy, there is a difference between genders ($p = 0.001$), i.e. male students have higher self-efficacy and social adaptation. The total score of social adaptation of male and female students ($p = 0.049$) and their environment overall acceptance ($p=.001$) is different depending on gender, the total score of social adaptation ($p=.008$) and learning adaptability ($p=.000$), adaptability with people ($p= .010$), adaptability of "I" ($p=.000$), adaptability to career choice ($p=.009$) are different to a certain extent. Also, social adaptation and self-efficacy have a moderately positive correlation ($r=.329$), and self-efficacy affects social adaptation by 10.8% ($\Delta R^2 = 0.108$).

Keywords: student, self-efficacy, social adaptation